



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 15 өдөр

Дугаар А/12

Номгон

Г 7
Хүмүүнлэгийн ордныг аймгийн Хөдөлмөр,
халамжийн үйлчилгээний газрын харьяанд
шилжүүлэх тухай

Баянхонгор аймаг нь 3988 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ба үүнээс 1498 нь төрөлхийн, 2490 нь олдмол бэрхшээлтэй иргэд байгаагаас шалтгаанаар нь авч үзвэл ердийн өвчин 77 хувь, ахуйн ослоор 15 хувь, үйлдвэрлэлийн осол 1 хувь, зам тээврийн осол 4 хувь, мэргэжлээс шалтгаалах өвчин 3 хувийг тус тус эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, ялангуяа тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг хүртээмжтэй, чанартай хүргэх, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.5.8 дахь заалтыг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулахаар Хүмүүнлэгийн ордныг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяанд шилжүүлсүгэй.

2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Хүмүүнлэгийн ордны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Э.Энхтөр)-т үүрэг болгосугай.

3.Хүмүүнлэгийн ордны 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв 120.000.000 (Нэг зуун хорин сая) төгрөгийг аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

642311976

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

